төсөл

Дүрэмд өөрчлөлт оруулах тухай

Цагдаагийн албаны тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/122 дугаар тушаалаар батлсан “Олон нийтийн цагдаагийн дүрэм, түүнд тавигдах шаардлага, гэрээний загвар”-ын 1.3 дахь хэсгийн “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хууль,” гэснийг “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль,” гэж, 2.4 дэх хэсгийн “энэ дүрмийн 2.4-д заасан” гэснийг “Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/121 дүгээр тушаалаар батлсан” гэж, 2.9 дэх хэсгийн “код-202, 205, 208, 213, 222, 224, 226, 243, 400, 401, 404, 408-д” гэснийг “код-202, 205, 207, 213, 214, 222, 223, 227, 231, 234, 243, 400, 401, 404, 406, 408-д” гэж, 5.3 дахь хэсгийн “цагдаагийн байгууллагаас олгосон торгуулийн хуудас ашиглах бөгөөд Сангийн сайд, Хууль зүйн сайд, Гадаад харилцааны сайд, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын хамтарсан 2013 оны 179/А/171/А/64/А/225 дугаар тушаалд зааснаар цагдаагийн байгууллага нь торгуулийн хуудсыг олгох, тайлан тооцоо хийх алба хаагчийг томилон ажиллуулна.” гэснийг “Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.2 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт зааснаар Засгийн газрын батлсан “Шийтгэлийн болон шийтгэлээс чөлөөлөх хуудасны маягт, хэрэглэх журам”-ыг баримтална.” гэж, 6.3 дахь хэсгийн “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан үүргээ биелүүлэх” гэснийг “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасан” гэж, 6.6 дахь хэсгийн “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 13 дугаар зүйлд” гэснийг “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 34 дүгээр зүйлд” гэж тус тус өөрчилсүгэй.

2.Мөн дүрмийн хавсралт 1 “Олон нийтийн цагдаатай байгуулах хөдөлмөрийн гэрээ”-ийн 1.2 дахь хэсгийн “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль,” гэснийг “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль,” гэж, 4.2.1 дэх заалтын “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 10.2.3-т” гэснийг “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 31.1.3-т” гэж, 5.6 дахь хэсгийн “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан “Иргэдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үүргээ биелүүлэх баталгаа”-гаар” гэснийг “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасан баталгаагаар” гэж, 5.10 дахь хэсгийн “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан” гэснийг “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасан” гэж, 7.4 дэх хэсгийн “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 13.1-д” гэснийг “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 34 дүгээр зүйлд” гэж тус тус өөрчилсүгэй.

3.Журмыг алба хаагчдаар судлуулж, мөрдүүлэх, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг цагдаагийн төв, алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дэд бөгөөд Нийслэлийн цагдаагийн удирдах газрын дарга /цагдаагийн хурандаа Д.Ядамдорж/-д даалгасугай.

5.Тушаалыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс эхлэн мөрдсүгэй.

ДАРГА, БРИГАДЫН
ГЕНЕРАЛ С.БААТАРЖАВ